


Эцэг эх, асран хамгаалагчдад зориулав

# 0-59 САРТАЙ ХҮҮХДИЙН ӨСӨЛТ ХӨГЖЛИЙН БҮРТГЭЛ



БҮРТГЭЛИЙН №

Хүүхдийн овог нэр:	Хүйс:	Төрсөн он	сар	өдөр	цаг
Төрсөн газар:	Төрөх үеийн жин	кг	Төрөх үеийн урт	см	
Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар:	<input type="text"/>				
Регистрийн дугаар:	<input type="text"/>				
Өрхийн хэд дэх хүүхэд:	Ам бүл:	<input type="text"/> <input type="text"/>		Хөхөө амласан хугацаа: /зур/ 1 цагийн дотор	
				түүнээс дээш	



unicef 

## 1. МЭДЭЭЛЭЛ, БҮРТГЭЛ

Эхийн овог нэр:	Боловсрол:	Шилжин суурьшсан тохиолдолд орон нутгийн эмнэлгийн хяналтанд орсон эсэхийг тэмдэглэх ..✓...
Эцгийн овог нэр:	Боловсрол:	1. <input type="checkbox"/> 2. <input type="checkbox"/> 3. <input type="checkbox"/>
Оршин суугаа газрын хаяг:		
1.	2.	3.

## 2. ТАНИЛЦУУЛГА

Бага насны хүүхдийн өсөлт хөгжлийн бүртгэл нь эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийнхээ өсөлт хөгжлийг хянах, шалгахад зориулсан өрхөд суурилсан хэрэгсэл юм. Зорилго нь эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн байдлын тухай мэдээллийг тогтмол олгосноор тэднийг хүүхдийнхээ бүрэн дүүрэн өсөлт хөгжлийг хангахад шаардлагатай дадал, чадвартай болгоход оршино. Өсөлт хөгжлийн бүртгэл нь хүүхдэд 2 хувь байх ёстой бөгөөд 1 хувь нь эцэг эх, асран хамгаалагчдад буюу өрх гэрт, нөгөө хувь нь эрүүл мэндийн байгууллагад хөтлөгдөнө. 0-35 сартай хүүхдүүд **сар бүр**, 36-59 сартай хүүхдүүд жил бүрийн **2, 5, 8, 11 дүгээр саруудад** тогтмол өсөлтийн хяналтад хамрагдана.

Хүүхэд болгон эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжлийн дэмжлэг, хүүхэд хамгааллын үйлчилгээнүүдийг цогцоор нь авч байх ёстой юм. Энэ нь таны хүүхэд хугацаандаа урьдчилан сэргийлэх тарилга болон сар бүр өсөлтийн хяналтанд хамрагдаж байх, насандаа тохирох үйлдлүүдийг хийж чаддаг байх, үүнийг нь эцэг эх, асран хамгаалагчид нь мэдэж дэмжлэгийг байнга үзүүлж байх, оршин суугаа газартаа бүртгэлтэй байж, шаардагдах үйлчилгээг авч чаддаг болохыг хэлж байгаа юм.

### Таны хүүхэд:

- ▶ Хоол тэжээлийн үйлчилгээг сар бүр өсөлтийн хяналтад хамрагдаж өсөлтийн хүснэгт дээрээ жингээ тэмдэглүүлэн, хоол тэжээлийн байдлаа тодорхойлуулж, эрүүл өсөхөд шаардлагатай нэмэлт үйлчилгээ, зөвлөгөө, аминдэм, бичил бодисоор үнэ төлбөргүй хангагдсанаар авах болно.
- ▶ Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг хөгжлийн үе шатны бүлэг үзүүлэлтүүдээс хүүхдийнхээ насанд тохирох хэсгийг нь уншиж ойлгосон эцэг эх, асран хамгаалагч хүүхдээ хийж чадаж байгаа эсэхийг ажиглаж, шалгаж дэмжсэнээр авах юм.
- ▶ Эрүүл мэндийн үйлчилгээг өсөлтийн хяналтанд хамрагдаж, эрүүл мэндийн ажилтнаас зөвлөгөө авах ба мөн эцэг эх өөрсдөө дархлаажуулалтын товлол бүхий хүснэгтээс харж мэдсэнээр хүүхдийнхээ насанд тохирсон урьдчилан сэргийлэх тарилгуудыг үнэ төлбөргүйгээр хийлгэн, бүрэн хийлгэсэн тохиолдолд “Бүрэн дархлаажуулагдсан хүүхэд”-ийн гэрчилгээтэй болсноор авах юм.

- ▶ Хүүхэд хамгааллын үйлчилгээнд дээрх бүх үйлчилгээ дэмжлэгийг авснаар хамрагдах боломжтой болно.

Таны хүүхэд хоол тэжээлийн болон эрүүл мэндийн, хөгжлийн дэмжлэгийн, хүүхэд хамгааллын үйлчилгээг гүйцэд авч чадсанаараа бүрэн дүүрэн өсч хөгжиж, эрүүл саруул, чадвартай иргэн болох юм.

### 3. ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДЫН ЗЭРЭГ ДАДЛУУД

**Эхийн сүүгээр хооллолт:** Хүүхдийг төрөнгүүт 1 цагийн дотор багтаан ангир уургийг нь амлуулаарай. Хүссэн үед нь хөхүүлнэ. 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллож, 2 нас хүртэл нь үргэлжлүүлэн хөхүүлээрэй.

**Нэмэгдэл хоол:** 6 сартайгаас нь эхлэн тохирсон нэмэгдэл хоолыг өгнө. Нэг удаадаа аягаас багагүй хэмжээтэйгээр өдөрт 3-5 удаа хооллоорой.

**Аминдэм, бичил бодисын хангалт:** Эрүүл мэндийн байгууллагаас 0-24 сартай хүүхэд бүрт жил бүрийн 10-аас 4 дүгээр саруудад Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар уулгадаг. Мөн 6 сартайгаас нь эхлэн жил бүрийн 5 дугаар болон 11 дүгээр сард А аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар уулгадаг. Төмрийн бэлдмэлийг урьдчилан сэргийлэх тунгаар зөвхөн цус багадалтай эхээс төрсөн, бага жинтэй төрсөн, ихэр төрсөн, тураалтай хүүхдүүдэд уулгадаг. Хоол хүнсэндээ иоджуулсан давсыг тогтмол хэрэглэж хэвшээрэй.

**Суулгалт:** Хүүхдийн баасны тоо, найрлага ердийнхөөс өөрчлөгдөн, эмгэг хольцтой (усан, цусан) болохыг суулгалт гэнэ. Суулгалт өвчний үеийн анхаарах шинжүүд: 1. Суулгана, 2. Бөөлжинө, 3. Хоолонд дургүй болно. Суулгах нь уг өвчний хамгийн тогтвортой илэрдэг гол шинж юм. Тоо нь олширвол та эмчид яаралтай хандаарай. Суулгалт өвчний шинж илэрвэл үргэлжлүүлэн хөхүүлж, ердийнхөөс илүү шингэн өгөөрэй. 2 нас хүртэл суулгалт бүрийн дараагаар 50-100 мл, 2-оос дээш настайд суулгалт бүрийн дараагаар 100-200 мл шингэн сэлбэх давсны уусмал өгөөрэй.


**Амьсгалын замын цочмог халдвар:** Амьсгалын замын халдварын үеийн анхаарах шинжүүд: 1. Шуугиантай амьсгалсан, 2. Амьсгал олширсон буюу маш олширсон, 3. Хөхөө хөхөхгүй буюу шингэн ууж чадахгүй болсон, 4. Биеийн байдал дордсон, 5. Халуурсан, 6. Цээж хонхолзох зэрэг амьсгалын замын цочмог халдварын шинж илэрвэл яаралтай эмчид ханд. Ханиад, шуухинаагийн үед аньс, түүний навчны ханд, зөгийн балтай сүү, чигатуссин, читамоныг өгөөрэй.

**Бусад өвчний үед илрэх аюултай шинжүүд:** 1. Татсан, 2. Амьсгал олширсон (нэг хоромд 60 буюу түүнээс олон) 3. Цээж хүчтэй хонхолзсон, 4. Хамар сарталзсан, 5. Яраглаж амьсгаадсан. 6. Чихнээс булаг гоожсон, 7. Зулай түмбийсэн, 8. Хүй нь улайсан буюу идээ гарсан, 9. Халуун ихэссэн (37.5°C буюу түүнээс дээш), 10. Халуун багассан (35.5°C буюу түүнээс доош), 11. Арьсан дээр идээт цэврүү гарсан, 12. Унтамхай буюу ухаангүй, 13. Хөдөлгөөн ердийнхөөс багассан, 14. Тавгүйргэх, 15. Нойр хоолондоо дургүйцэх зэрэг шинжүүд илэрвэл нэн даруй эмчид хандаарай.


**ХДХВ/ДОХ/БЗДХ:** Хүний дархлал хомсдлын вирус/Дархлалын олдмол хомсдол болон зарим Бэлгийн замаар дамжих халдвар нь 1. Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох, 2. Халдвартай эхээс хүүхдэд, 3. Шинжлэгдээгүй цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх, 4. Халдвартай зүү, тариур дамжуулан хэрэглэхэд халдварладаг. Иймд ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэхийн тулд тохиолдлын бэлгийн хавьталд орохгүй байх, бэлгэвч тогтмол хэрэглэж занших, шинжлэгдсэн цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх, нэг удаагийн зүү, тариур хэрэглэж байх шаардлагатай. Эхчүүд жирэмсэн үедээ ХДХВ/БЗДХ-ын шинжилгээнд эрт хамрагдаж, хэрэв халдвар илэрсэн тохиолдолд эмчилгээ хийлгэснээр хүүхэддээ халдвар дамжуулахгүй байх боломжтой.

## 4. ӨСӨЛТИЙН ХҮСНЭГТИЙГ УНШИХ


### Өсөлтийн муруй



Сайн буюу хэвийн



Муу буюу аюултай



Маш муу буюу маш аюултай

### Хоол тэжээлийн байдал

- Илүүдэл жинтэй / +2SD-с дээш
- Хэвийн жинтэй / +1SD-с -1SD
- Тураалын дунд хэлбэр / -2SD
- Тураалын хүнд хэлбэр / -3SD

**Өгссөн - сайн буюу хэвийн.** Хүүхдийн биеийн жин сар бүр нэмэгдэж байх ёстой бөгөөд үүнийг өсөлтийн муруй байнга өгсөж байгаагаар мэднэ.

**Тэгширсэн – муу буюу аюултай.** Хүүхдийн биеийн жин 2 буюу 3 сар дараалан нэг хэвэндээ байж өсөлт зогсонгишсон үед өсөлтийн муруй тэгширнэ.

**Уруудсан – маш муу буюу маш аюултай.** Хүүхэд биеийн жингээ алдаж байгааг илтгэх маш муу үзүүлэлт юм. Хоол тэжээл хангалтгүй авах, эсвэл өвчлөх гэсэн 2 шалтгаанаар хүүхэд биеийн жингээ алдах буюу байх ёстой жиндээ хүрэхгүй болдог. Өсөлтийн муруй тэгширсэн эсвэл уруудсан үед шалтгааныг нь тодорхойлж хариу арга хэмжээг яаралтай авах хэрэгтэй.

## 5. ӨСӨЛТИЙН ХҮСНЭГТ ДЭХ ТЭМДЭГЛЭГЭЭ

### Биеийн жинг тэмдэглэх:

- Тэмдгийг хүүхдийг жинлэсний дараа өсөлтийн хүснэгтэд хүүхдийн насанд тохирох сарын босоо шугамыг тухайн сард байгаа жингийн хэвтээ шугамтай харгалзуулан уулзуулж огтолцсон цэг дээр тод өнгөөр тавина. Төрөх үеийн жинг өсөлтийн хүснэгтийн хамгийн эхний баганы босоо шугам дээр тохирох жинд нь харгалзуулан тэмдэглэнэ. Сар бүрийн тэмдгийг хооронд нь зураасаар холбосноор хүүхдийн өсөлтийн муруйг үүсгэнэ. Хүүхэд жинлэх жингийн нарийвчлал 100 гр байх ёстой.

### Хооллолтын байдлыг тэмдэглэх:

Өсөлтийн хүснэгтийн хамгийн доод хэвтээ мөрөнд (1-2 кг-ийн хоорондох зайд) зөвхөн нэг хүртэлх насны хүүхдийн хооллолтын байдлыг насны босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд дараах тэмдэгүүдээр сар бүр тэмдэглэнэ. Үүнд:

- Д** - Эхийн сүүгээр дагнан хооллож байгаа бол,
- У** - Угжаар хооллож байгаа бол,
- Х** - Холимог хоолтой бол (Эхийн хөхний сүү + Эхийн сүү орлуулагч),
- Н** - Нэмэгдэл хоолонд орсон эсвэл хооллож байгаа бол,
- ↑** - Тэмдгээр хөхнөөс гарсан хугацааг өсөлтийн хүснэгтийн доод талын стандарт муруй (улаан) шугам хүртэл насны босоо зураасын дагуу үргэлжлүүлэн татаж тэмдэглэнэ.

#### **Аминдэм, бичил бодисын хангалтыг тэмдэглэх:**

- \*** - Хэрэв А аминдэм уусан бол (1 хүртэл насанд 2-3 кг-ийн, 1-2 насанд 3-4 кг-ийн, 2-5 насанд 4-5 кг-ийн хоорондох зайд) тухайн сарын босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд дээрхи тэмдгээр тэмдэглэнэ,
- ✓** - Д аминдэм уусан бол 5-аас 6 кг-ийн хоорондох зайд тухайн сарын босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд тэмдэглэнэ,
- ♦** - Эмчийн заавраар урьдчилан сэргийлэх тунгаар олгосон төмрийн бэлдмэлийг бүгдийг ууж дууссан бол 7-оос 8-н кг-ийн хоорондох зайд тухайн сарын босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд тэмдэглэнэ.


#### **Өвчлөлийн байдлыг тухайн сарын босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд тэмдэглэх:**

- А** - Хэрэв хүүхэд тухайн сард амьсгалын замын цочмог халдвараар өвдсөн тохиолдолд 9-өөс 10 кг-ийн хоорондох зайд,
- А1** - Амьсгалын замын цочмог халдвараар өвдөн эмнэлэгт үзүүлсэн эсвэл эмчлүүлсэн бол 9-өөс 10 кг-ийн хоорондох зайд,
- С** - Суулгалтаар өвдсөн тохиолдолд 11-12 кг-ийн хоорондох зайд,
- С1** - Суулгалтаар өвдөн эмнэлэгт үзүүлсэн эсвэл эмчлүүлсэн бол 11-12 кг-ийн хоорондох зайд,
- К** - Улаан бурхан өвчнөөр өвдсөн тохиолдолд 12-13 кг-ийн хоорондох зайд
- Б** - Бусад өвчнийг өвдсөн үед нь 12-13 кг-ийн хоорондох зайд тус бүр тэмдэглэнэ.


#### **Хүүхэд хамгаалал, нийгэм сэтгэлзүйн дэмжлэгийг тэмдэглэх:**

- Г** - Хүүхэд ямар нэг хэлбэрийн гэмтэл авсан бол 13-14 кг-ийн хоорондох зайд тухайн сарын босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд
- Ц1** - Хүүхэд нийгэм сэтгэлзүйн хөгжлийг дэмжих хувилбарт сургалтад (гэр цэцэрлэг, явуулын багш, эцэг эх өөрөө дэмжлэг үзүүлж байгаа) хамрагдаж байгаа бол 14-15 кг-ийн хоорондох зайд тухайн сарын босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд
- Ц2** - Ясли, цэцэрлэгт хамрагдаж байгаа бол 14-15 кг-ийн хоорондох зайд тухайн сарын босоо шугамын өмнөх дөрвөлжин нүдэнд тэмдэглэнэ.

## 6. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ӨСӨЛТИЙН ХҮСНЭГТ




0-1 нас сараар



**3 нас сараар**

**сараар**

**0-35 сартай хүүхдүүд сар бүр тогтмол өсөлтийн хяналтад хамрагдах ёстой.**



**4 нас сараар**

**5 нас сараар**

36-59 сартай хүүхдүүд жил бүрийн 2, 5, 8, 11 дүгээр саруудад тогтмол өсөлтийн хяналтад хамрагдах ёстой.

## 7. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТНЫ БҮЛЭГ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эцэг эх, асран хамгаалагч, эрүүл мэндийн ажилтан, багш та бүхэнд хүүхдийнхээ хөгжлийн түвшинг үнэлэхдээ түүний насанд тохирох бүлэг үзүүлэлтүүдийг анхааралтай уншихыг зөвлөж байна. Хэрэв таны хүүхэд тухайн үзүүлэлтэд тохирох чадварыг эзэмшсэн байвал өгүүлбэрийн өмнөх дөрвөлжин нүдэнд ...✓... тэмдэг тавиарай.

Хэрвээ хүүхэд насандаа тохирох дээрх бүлэг үзүүлэлтүүдээс нэг буюу хэсэг бүлгийг хийж чадахгүй байвал эцэг эх, асран хамгаалагч та эрүүл мэндийн ажилтан, багш, сайн дурын идэвхтэнд хандаж зөвлөгөө аваарай.

### Нярай хүүхэд

#### Бие бялдрын хөгжил

- Хөхөө хөхөж чадна.
- Ихэвчлэн, тайван унтана.
- Түрүүлгэ нь харуулан хэвтүүлэхэд эрүүгээ бага зэрэг өргөнө.
- Гарт бариулсан бүхнийг атгана.

#### Оюуны хөгжил

- Ойрхон буюу 15-20 см-ын зайд байрлуулсан зүйлийг харна.
- Дуу чимээ гарсан зүг рүү толгойгоо эргүүлнэ.
- Шээсэн, өвдсөн болон таатай биш байгаа үед уйлна.

#### Нийгэмшихүйн хөгжил

- Эхийгээ танина.
- Анхаарал татах гэж уйлна.
- Эхийнхээ хайр энхрийллийг мэдэрнэ.



### 1 сартай хүүхэд

#### Бие бялдрын хөгжил

- Түрүүлгэ нь харуулж хэвтүүлэхэд түр хугацаанд толгойгоо өргөнө.
- Толгойгоо арай ядан даана.

#### Оюуны хөгжил

- Хүний царай болон тод өнгийн зүйлсийг сонирхож харна.
- Өөрөөс нь 20-30 см зайд байрлуулсан хөдөлж буй зүйлрүү харна.
- Таатай үед ганганана.

#### Нийгэмшихүйн хөгжил

- Эцэг эхийгээ өөрт нь хандан ярихад нүүр үрүү нь харна.
- Хайр энхрийлэл хүссэн болон ямар нэг хэрэгцээ шаардлагатай байгаагаа уйлж илэрхийлнэ.



### 2 сартай хүүхэд

#### Бие бялдрын хөгжил

- Түрүүлгэ нь харуулж хэвтүүлэхэд толгойгоо арай удаан хугацаагаар өргөнө.
- Гартаа тааралдсан зүйлийг атгана.

#### Оюуны хөгжил

- Түрүүлгэ нь харуулж хэвтүүлсэн үед удаан хөдөлж буй зүйлийг толгойгоо эргүүлэн дагуулж харна.
- Дуу чимээ гарсан зүг үрүү толгойгоо эргүүлж харна.
- Өглөө сэрмэгц тайван хэвтэж ганганана.

#### Нийгэмшихүйн хөгжил

- Эх болон ойр дотны хүмүүсээ таньж инээмсэглэнэ.
- Анхаарал халамж хэрэгтэй болон хоол идэхийг хүссэн үедээ уйлна.



### 3 сартай хүүхэд

#### Бие бялдрын хөгжил

- Өвөр дээрээ тэврэн зогсоход толгойгоо сайн даана.
- Хөдөлж буй зүйл үрүү гараа сунгаж, барьж авахыг оролдоно.

#### Оюуны хөгжил

- Хүний дуу хоолойг сонссон, түүний нүүр царай болон бусад зүйлийг харсан үедээ хоолойгоо татан дуугарч, толгой, гар, хөлөө хөдөлгөнө.

- Дуу чимээ гарсан зүг үрүү толгойгоо эргүүлж, түүнийг харцаараа хайна.
- Хөгжим сонсоно.
- Гараараа өөрийнхөө нүүр, нүд болон аманд хүрнэ.

#### Нийгэмшихүйн хөгжил

- Эцэг эх болон ойр дотны хүмүүсээ таньж инээмсэглэнэ.
- Эх нь орхиж явахад уйлна.
- Анхаарал халамж хэрэгтэй болон хоол идэхийг хүссэн үедээ уйлна.



### 4 сартай хүүхэд

#### Бие бялдрын хөгжил

- Түүрүүлгэ нь харуулж хэвтүүлэх болон гараараа түшин суулгахад толгойгоо бүрэн даана.
- Хэвтэж байхдаа эргэж хөврөөнө
- Хүүхдийг өвөр дээрээ тэврэхэд тэнцвэртэйгээр зогсоно.

#### Оюуны хөгжил

- Халбагаар хооллоход амаа ангайна.
- Ойр орчимд нь гарсан дуу чимээ болон хөдөлгөөнийг сонинучирхан сонсох буюу ажиглана.
- Гар хүрэх зайд байгаа зүйлийг барьж авна, үзэж сонирхоно.
- Түүнд хандан ярихад хоолойгоо татаж, дуу авиа гаран гангана.
- Түүнтэй тоглоход инээнэ.

#### Нийгэмшихүйн хөгжил

- Эх болон түүнийг хооллож буй хүн үрүү харж инээмсэглэнэ
- Эхийгээ хараад баяртай байгаагаа дуу гаргах болон хөлөө тийчлэх байдлаар илэрхийлнэ.
- Усанд оруулахаар савтай усанд дүрэхэд чичрэнэ. (нүд нь том болж, биеэ чангалан гараа дээш өргөнө)
- Шээсэн болон өлссөн үедээ уйлна.



### 5 сартай хүүхэд

#### Бие бялдрын хөгжил

- Гараараа тулж цээж болон биеэ өргөнө.
- Бусдын дэмжлэггүйгээр түр хугацаанд сууна.
- Суганаас нь тулж зогсоход толгой болон биеэ тэгш байлгана.
- Доош харуулан хэвтүүлсэн үед мөлхөх оролдлого хийнэ.

#### Оюуны хөгжил

- Барьж буй зүйлээ нэг гараасаа нөгөө гартаа шилжүүлнэ.
- Эд зүйлсийг сонирхож гартаа атган, амандаа хийнэ.
- Хөдөлж буй зүйлд анхаарал нь татагдана.
- Ба, ма, га, да гэх мэтийн авиа гаргана.

#### Нийгэмшихүйн хөгжил

- Толинд харахдаа дуртай байна.
- Бусад хүмүүс түүнтэй ярихад гараа хөдөлгөж, дуу авиа гаргана.
- Эцэг эх болон бусад хүн түүнтэй тоглоход чанга дуугарч инээнэ.



### 6-8 сартай хүүхэд

#### Бие бялдрын хөгжил

- Бусдын тусламжгүйгээр сууна.
- Мөлхөнө.
- Сууж байх үед нь гараас нь барихад татаж босно.

#### Оюуны хөгжил

- Эд зүйлсийг илүү хөдөлгөөний эвсэлтэйгээр барьж авна.
- Хөлийн хуруунуудаа хөхөнө, биеийн хэсгүүдээ "судлана".
- Нэрээр нь дуудахад толгойгоо эргүүлэн харна.
- Усаар тоглохдоо дуртай байна, зарим эд зүйлсийг таньж эхлэнэ.
- Дохио зангаа болон үйлдлүүдийг хийж сурна.
- Аав, ээж гэх мэтийн зарим богино үетэй үгийг хэлнэ.

#### Нийгэмшихүйн хөгжил

- Эцэг эх болон гэр бүлийнхээ бусад гишүүдийг танина.
- Ах эгч нартайгаа тоглох дуртай байна.
- Танихгүй хүмүүсийг хараад айж гэрэвшинэ.



## 9-11 сартай хүүхэд

### Бие бялдрын хөгжил

- Юм түшин хажуулдаж явна, богино хугацаанд ганцаараа зогсоно.
- Жижиг зүйлсийг эрхий болон долоовор хуруугаараа барьж сурна.

### Оюуны хөгжил

- Ямар нэгэн нүх рүү хуруугаа хийх дуртай болно, савыг эд зүйлсээр дүүргэх буюу түүнийгээ асгах дуртай болно.
- Хөгжмийн аяар биеэ хөдөлгөнө, найгана, цогино.
- Хоёр үетэй богино үгнүүд хэлж сурна. Бусдын зааврыг биелүүнэ. (баяртай гээрэй гэхэд гараа даллана.)

### Нийгэмшихүйн хөгжил

- Ах эгч нартайгаа тоглоно, хүнд илүү дасамтгай болно.
- Хөгжим сонсоод найгана.



## 12-14 сартай хүүхэд

### Бие бялдрын хөгжил

- Ганцаараа сууна, явган сууна.
- Ганцаараа зогсоно, хэдэн алхам хийнэ.

### Оюуны хөгжил

- Зааврыг дагаж биелүүлнэ.
- Эд зүйлсийн бүтцийг ихэд сонинчирхана.
- Зарим үгсийг хэлж сурна.
- Ойр зуурын харилцан яриаг ойлгож эхэлнэ.

### Нийгэмшихүйн хөгжил

- Дуу сонсоод, биеэ хөдөлгөнө.
- Ганцаараа тоглоно.
- Бие дааж хооллохдоо дуртай байна.
- Заримдаа санамсаргүйгээр болон үнсэхийг хүссэн үед аав, ээжийгээ үнсэнэ.



## 15-17 сартай хүүхэд

### Бие бялдрын хөгжил

- Богино зайд гүйхийг оролдоно.
- Хоёр гараараа бөмбөг шидэхдээ тэнцвэрээ хадгалж чадахгүй унана.

### Оюуны хөгжил

- Амаа ангай, хэлээ гарга гэх мэтийн жирийн заавруудыг ойлгоно.
- Биеийнхээ эрхтнүүдийг мэддэг болно.
- Богинохон дуу дуулах, шүлэг уншихдаа дуртай байна.
- Мэддэг эд зүйлсийг нь асуухад хуруугаараа заана.

### Нийгэмшихүйн хөгжил

- Бусад хүүхдүүдтэй хамт байхдаа ч гэсэн ганцаараа тоглоно.
- Танил хүмүүстэйгээ харилцах дуртай байна.
- Өөрт анхаарал тавихыг шаардана.



## 18-20 сартай хүүхэд

### Бие бялдрын хөгжил

- Тэнцвэр сайтай алхана, арагшаа болон хажуу тийшээ алхана.
- Сайн гүйх боловч зогсох үедээ унана.
- Сараачин сурна.

### Оюуны хөгжил

- Эд зүйлсийг хүнд шилжүүлэн өгч чадна.
- Хүн болон эд зүйлсийг нэрээр нь нэрлэнэ, мэддэг үгнүүдээ хэлнэ.
- Ямар нэг зүйлийг хаана байгааг асуусан үед хуруугаараа заана.
- Үхэр шиг мөөрөх зэргээр мэддэг, эсвэл таалагдсан дуу авиагаа дуурайна.

### Нийгэмшихүйн хөгжил

- Эд юмсыг хөдөлгөх, байрлалыг нь шилжүүлэх дуртай болно.
- Хийсэн зүйлийнхээ үр дүнд сонирхолтой байгаагаа харуулна.
- Хувцсаа тайлахыг оролдоно.
- Тэврэхэд хариуд нь бас тэврэнэ.
- Өөртэй нь тоглосон үед инээнэ, ход ход инээнэ, ганганана.



## 21-24 сартай хүүхэд

### Бие бялдрын хөгжил

- Богино хугацаанд өлмий дээрээ зогсоно.
- Бөмбөгийг урагш өшиглөнө.
- Шатны баруулаас бариад хөлөө нэг нэгээр нь зөөж өгсөнө.

### Оюуны хөгжил

- Өөрийн болон өхөөрдсөн нэрээ мэддэг болно.
- Ганцаараа дуулах болон бүжиглэх дуртай болно.
- Эд юмс бүгд нэртэй болохыг мэддэг болно.
- Өлссөн, цангасан үедээ хоол, ус нэхнэ.
- Шүлэг сонсох дуртай болно.
- Нэг үетэй үгнүүдийг хэлдэг болно.



### Нийгэмшихүйн хөгжил

- Гэр ахуйн ажилд оролцох дуртай болно, тоос арчих, хог шүүрдэх, цэцэг услахыг оролддоно.
- Гадаа тоглох дуртай болно, өөрийн тоглоомуудаа өмчирхөнө.
- Айж байгаагаа илэрхийлнэ.

## 3 настай хүүхэд

### Бие бялдрын хөгжил

- Сайн гүйж чадна, гүйх үедээ огцом эргэж чадна.
- Бөмбөг шидэх буюу өшиглөх үед тэнцвэрээ хадгалж чадна.
- Хөлөө нэг нэгээр нь зөөж шатаар өгсөнө.

### Оюуны хөгжил

- 9 шоог дээрээс нь давхарлаж чадна.
- Богино өгүүлбэр болон нэг үгээр ярина, хүүхдийн богино шүлэг уншиж чадна
- Анхаарал төвлөрөх хугацаа маш богино бөгөөд анхаарал нь нэг зүйлээс нөгөө маш хурдан шилжинэ.

### Нийгэмшихүйн хөгжил

- Бусдын анхаарлыг өөртөө татах, найздаа болон өөртөө тохиолдсон явдлыг сонсох, ярих дуртай болно.
- Гутал, хувцсаа өөрөө өмсөж чадах боловч үдээсээ үдэж, товчоо товчилж чадахгүй.
- Үсээ самнахыг оролддоно.



## 8. ДАРХЛААЖУУЛАЛТ

Вакциныг товллолын дагуу хугацаанд нь хүүхэддээ хийлгэсний дараа хүснэгтийн тохирох нүдэнд хийлгэсэн он, сар, өдрийг бичнэ. Жишээ нь: 05/12/05 (өдөр, сар, он)

Вакцины нэр тун	Хийлгэх хугацаа							
	Төрсний дараа 24-48 цагийн дотор	2 сартайд	3 сартайд	4 сартайд	8-11 сартайд	1 настайд	2 настайд	
Сүрьеэ (I тун)								
Халдварт саа (I, II, III, IV тун)								
Гепатит В (I, II, III тун)								
Гуравт (Сахуу, Хөхүүл ханиад, Татран) (I, II, III, IV тун)								
Улаан бурхан (I, II тун)								
Тавт (Сахуу, Хөхүүл ханиад, Татран, Гепатит В, Хемофилюс инфлюэнзе В) (I, II, III тун)								

Таны хүүхэд сүрьеэгийн эсрэг вакцины 1 тун, халдварт саагийн эсрэг вакцины 4 тун, гепатит В-ийн эсрэг вакцины 3 тун, сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг гуравт вакцины 3 тун, улаан бурханы эсрэг вакцины 2 тунг хийлгэснээр **"Бүрэн дархлаажуулагдсан хүүхэд"** болж сум, хорооныхоо Засаг даргаас гэрчилгээг гардаж авна. Нэг наснаас хойш гуравт вакцины сэргээх тунг зайлшгүй хийлгэх ёстой.